

ШИВЭЭГОВЬ СУМЫН 2024 ОНЫ 07 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

2024.07.22

Шивээговь сум

НЭГ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

САЛБАРЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

Сумын Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 1 удаа зохион байгуулж, сумын Засаг даргаас 4 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг тооцон ажилласан.

Сумын Засаг даргын Зөвлөлийн хурлыг 07 дугаар сард зохион байгуулаагүй байна.

“Шивээговь сум мэдээ” цахим хаягаар нийт-80 мэдээллийг нийтлэн, бусад байгууллагын 13 мэдээллийг шэйрлэн, шинээр-67 мэдээ мэдээллийг иргэдэд хүргэн ажилласан. 2024 оны 07 дугаар сарын 22-ны байдлаар сумын цахим хуудасны нийт дагагчийн тоон үзүүлэлт- 4453 болсон байна. Сумын хэмжээнд болж буй цаг үеийн мэдээ, мэдээлэл, ажлын байр, арга хэмжээ гэх мэдээллүүдийг тогтмол оруулан, бусад зар мэдээллийн 8 группэд дамжуулан иргэдэд хүргэн ажиллаж байна.

Хөдөлмөр эрхлэлт болон халамжийн үйлчилгээг нийт 81 иргэнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 20 иргэнд, халамжийн 11 төрлийн үйлчилгээг 61 иргэнд тус тус хүргэсэн байна. Мөн Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн 4 төрлийн төсөл арга хэмжээний төсөл болон Нийгмийн халамжийн хэлтсийн Олон нийтийн оролцооны бүлгийн төсөл хүлээн авч байна. Амьжиргаа дэмжих зөвлөлийн хурлыг 2024 оны 07 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулж, малжуулах төсөлд хамрагдахаар төсөл ирүүлсэн нийт 12 иргэний 6 төслийг хэлэлцэж шийдвэрлүүлсэн.

ХОЁР. ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

САЛБАРЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

Тулгар төрийн 2233, Их Монгол Улсын 818, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113, Ардын Хувьсгалын 103 жилийн ой, Шивээговь сум үүсэн байгуулагдсаны 35 жилийн ойн баяр наадмыг 2024 оны 07 дугаар сарын 08, 09-ний өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүллээ. Нээлтийн үйл ажиллагааг Говьсүмбэр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ш.Билэггүмбэрэл, Шивээговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга А. Дэлгэрзаяа, Сумын Засаг дарга Ч.Сугармаа нар нээж, наадамчин олонд баяр наадмын мэндчилгээ дэвшүүллээ. Нээлтийн үеэр Үндэсний их баяр наадмыг угтан улс, орон нутгийнхаа эдийн засаг, нийгмийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулан төрийн дээд одон медалиар шагнагдаж байгаа иргэддээ хүндэтгэл үзүүлэх мөн салбарын болон аймаг, орон нутгийн шагналаар шагналаа.

Онцгой байдлын Ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/178 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/187 дугаар “Шуурхай штаб байгуулах тухай” захирамжийг үндэслэн сумын Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 21-ний А/80 дугаар захирамжаар “Сумын шуурхай штаб”-ыг байгуулан, томилгоожуулан ажилласан байна. Үер усны аюулын үед ашиглах шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, бэлэн байдалд бэлтгэн, нэмэлтээр худалдан авах, онцгой байдлын бэлтгэл хангах үүднээс сумын Онцгой байдлын “Гамшгийн зардал”-аас 5 сая төгрөгийн төсвөөр тоног төхөөрөмж нэмж авахаар ажиллаж байна.

Говьсүмбэр аймаг байгуулагдсаны 30 жилийн ой, “Боржигин наадам”, “Шивээговь сум байгуулагдсаны 35 жилийн ой” зэрэг ойн баяруудтай холбоотойгоор суманд бүтээн байгуулалт, тохижилтын ажлууд шат дараатайгаар хийгдэж байна. Эхний байдлаар:

- ✚ “Илчлэг Шивээ” ААТҮГ нь сумын Нутгийн удирдлагын ордны урд талбайд байрлах “Цэцэрлэгт хүрээлэнг засварлах, өнгө үзэмжийг сайжруулах” ажлын дагуу тус хүрээлэнгийн хашааг сэлгэн янзалж, өнгө будгийг сэргээх, нарнаас саатах саравчнуудыг шинээр байршуулах, лед

гэрэлтүүлгэн хэсэг, хүрээлэнгийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэхээр 1000ш мод бутыг суулгах ажлыг хийгээд байна.

- ✚ ЗДТГ нь байгууллагын дотоод тохижилтын ажлыг эхлүүлэн, өөрсдийн нөөц боломжийн хүрээнд үүдний хэсэг, кродирын засварыг хийлгэн ажиллаж байна.
- ✚ “Шивээ-Овоо” ХК нь сумын төв талбайн тохижилт, гэрэлтүүлэг зэргийг шинэчлэх ажлыг хийсэн байна.
- ✚ “Эрүүл мэндийн төв” нь хүүхдийн тоглоомын талбайн эвдэрч хэмхэрсэн хашаа, тоглоом, сандал, саравч зэргийг сэргээн засварлаж, өнгө будгийг сэргээгээд байна.
- ✚ Соёлын төв нь байгууллагын тайзны өргөтгөл болон хэв загварт өөрчлөлт шинэчлэл хийж, засварлуулаад байна.

Сумын Сонгуулийн хороо, Хэсгийн хороодууд холбогдох хууль дүрэм журмыг мөрдлөг болгон, хуульд заасан хугацааны дагуу ажил чиг үүргээ гүйцэтгэн ажилласан байна. 2024 оны 06 дугаар сарын 28-ны өдөр улс даяар сонгуулийн санал авах өдөр болж, сумын Сонгуулийн хороо болон Сонгуулийн хэсгийн хороод санал авах үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан.

ГУРАВ. ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ТӨСӨВ САНХҮҮГИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД

САЛБАРЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

2024 оны 07 дугаар сарын байдлаар сумын төсвийн орлого төлөвлөгөөгөөр 16 төрлийн татварын орлого гүйцэтгэлээр 1,200,643,546 төгрөг бүрдэж, биелэлтээр 90.46%-тай бүрдсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн 6н байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. 2024 оны 07 дугаар сарын шилэн дансны мэдээ оруулалтын байдал 100 хувьтай, байршуулвал зохих 420 мэдээллийг ил тод мэдээллэсэн байна.

ДӨРӨВ. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

САЛБАРЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

“ШИНЭ-ХОРШОО ХӨДӨЛГӨӨН”

2024 оны 07 дугаар сарын байдлаар Шивээговь сумын хэмжээнд шинэчлэн байгуулагдсан 2, шинээр байгуулагдсан 5 хоршоод байгаа бөгөөд тус малчдын хоршоонд төсөл сонгон шалгаруулалтаар газар эзэмшүүлэхээр 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлтээр 4-н байршилд газар төлөвлөн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Тус байршлуудад төсөл сонгон шалгаруулалт зарлах тухай сумын Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 20-ны А/79 дугаар захирамжийн дагуу сумын төвөөс урагш 2 байршилд, сумын төвөөс баруун тийш 2 байршил нийт 4-н байршилд төсөл сонгон шалгаруулалт явуулах зар мэдээг газрын биржийн цахим систем www.mle.mn-д байршуулсан байна. Мөн Шивээговь сумын мэдээ мэдээллийн нэгдсэн зарын групп болон www.govisumber.qazar.gov.mn-ээр зарыг байршуулж ажилласан байна. Төсөл сонгон шалгаруулалтын дагуу ирүүлсэн төслүүдийг сумын Засаг даргын 2024 оны 07 сарын 04-ний А/89 тоот “Төсөл сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулах тухай” захирамжийн дагуу 5-н хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгээр 2024 оны 07 сарын 05-ны өдөр 100%-ийн ирцтэйгээр хуралдаж нийт 3-н байршилд 3-н төсөл ирүүлснийг ажлын хэсгээр хэлэлцэн дүгнэж шийдвэрлээд байна.

ТАВ. ДЭД БҮТЭЦ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

САЛБАРЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

1. - **Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар** батлагдсан 2 ажлыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарласан. Үүнд:
 - ✓ Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх, засвар үйлчилгээний ажил /07.05/
 - ✓ Ёслол хүндэтгэлийн өргөө гэр авах ажлуудын тендерийг /06.26/ зарлаад байна.

Нийтийн эзэмшлийн орон сууцны 3-р байрны техникийн давхрын шугам сүлжээний өргөтгөл шинэчлэлийн ажлыг хүлээн авах ажлын хэсгийг сумын Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/88 дугаар захирамжаар 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тус ажлыг 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдөр 100%-ийн гүйцэтгэлтэйгээр хүлээж аваад байна.

Шивээговь сумын 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх Ус хангамжийн нэмэлт их үүсвэр, шугам сүлжээний автоматжуулалтын ажил, Хуучин хог хаягдлыг булшлах, шинээр хогийн цэг байгуулах ажил, Цэцэрлэгийн хашааг шинэчлэх ажил, сумын Нэрт багийн нутаг дэвсгэрт Нийтийн биеийн тамирын талбай/хөл бөмбөгийн талбай/ байгуулах зэрэг ажлууд хийгдэж, 30-70%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-т заасныг үндэслэн худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгон зарласан байна. Үүнд:

- Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарласан-2

ЗУРГАА. НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

САЛБАРЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

Боловсролын чиглэлээр: Сумын Ерөнхий боловсролын сургууль нь хүүхдийн дуу хөгжмийн боловсролыг хөгжүүлэх, амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, Боржигон наадмын бэлтгэл ажлыг хангах зорилгоор дараах чиглэлээр дугуйлан хичээллүүлж байна. Үүнд:

- Боржигон морин хуур: дунд ахлах ангийн 9 сурагч
- Даралтат хөгжим: бага ангийн 8 сурагч
- Мастер морин хуур: бага ангийн 3 сурагч
- Найрал дуу: бага дунд ангийн 9 сурагч тус тус хичээллэж байна.

ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

“Хог хаягдлын менежмент” арга хэмжээний хүрээнд төсвийн байгууллагууд, ААН-үүд 14 хоног тутам өөрийн эзэмшлийн 50м хүртэлх газрын хог хаягдлыг цэвэрлэж байна. Мөн хог хаягдлын хураамж тогтоотой холбоотой иргэдээс авах саналыг цахимаар болон цаасаар боловсруулж сумын олон нийтийн сүлжээнд байршуулсан. Эхний байдлаар цахимаар 21, цаасаар 35 санал аваад байна.

Сумын хэмжээнд золбин нохой муур устгалын ажлыг 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулан ажилласан. Устгалаар 1-15-р байр, зүүн гэр байр, урд гэр байр маршрутаар нохой устгалыг хийж, 27 нохой 18 муурыг устгаж 3 кг ариутгалын бодисоор халдваргүйжүүлэлт хийж булж устгаад байна.

МЭДЭЭГ БЭЛТГЭСЭН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН

МЭРГЭЖИЛТЭН

М.ГАНТУЯА

ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ